



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 11 дугаар сарын 08

Дугаар 13/03

Баян-Өндөр сум

2024 онд ойгоос бэлтгэх модны  
дээд хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/456 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөг харгалзан 2024 онд Жаргалант сумын хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг (ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 100 шоо метр, түлээний шинэс мод 800 шоо метр) баталсугай.

2.Холбогдох хууль, тогтоомжийн дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо, хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. МӨНХБАТ